

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛАВ.

Улаанбаатар дахь Оросын шинжлэх ухаан соёлын төв, Дорноговь аймаг, АШУҮИС-ийн Дорноговь салбар сургууль хамтран ажиллахаар гурвалсан гэрээг 2022 оны 11-р сарын 7-ны өдөр байгуулав. Тус гэрээнд Россотрудничество агентлагийн Монгол улс дахь төлөөлөгчийн газрын тэргүүн Базерхандаев, Дорноговь аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Байгалтуяа, АШУҮИС-ийн Дорноговь салбар Анагаах ухааны сургуулийн захирал Ц.Цабшир нар гарын үсэг зурав.

Мөн хамтын ажиллагааны хүрээнд Оросын шинжлэх ухаан соёлын төвийн дэргэдэх Орос хэлний төвийг салбар сургууль дээр байгуулж нээлтээ хийлээ. Орос хэлний төвийн нээлтэнд Россотрудничество агентлагийн Монгол улс дахь төлөөлөгчийн газрын тэргүүн Базерхандаев оролцож 140 төрлийн 179 ширхэг 2617,72 долларын өртөг бүхий мэргэжлийн болон орос хэл, уран зохиолын номыг тус төвд хүлээлгэн өглөө.